

Сургалтын орчны нөлөөллийн хүчин зүйлийн судалгаанд Пирсоны шинжилгээг хэрэглэх нь

Г.Уртнасан, С.Эрдэнэтуяа
Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль*

Хураангуй

Сургалтын орчин нь боловсролын чанарын түвшинг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг хэмээн авч үздэг байна. Аливаа зүйлийн оршин тогтнох, үйл гүйцэтгэх шалтгааныг хүрээлэн буй орчин бий болгодог юм бол хүн суралцахад ямар таатай орчин шаардлагатай вэ? гэдэг асуулт гарч ирнэ. Бидний судалгааны ажлын гол хэсэг ч үүнд чиглэж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Их, дээд сургуулийг төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар буюу сургалтын чанар нь суралцах орчноос хамаарна хэмээн үзэж дээд боловсролын сургалтын орчныг сайжруулах үндэслэлийг ул суурьтай тодорхойлох шаардлагатай. Энэ нь оюутны суралцах хандлагатай харилцан хамааралтай асуудал юм. Сургалтын үйл ажиллагаа нь оюутан-багш-сургууль гэсэн 3 талын оролцоотой бөгөөд түүний үр дүн болон чанарт сургалтын орчин ихээхэн нөлөөтэй. Сургалтын орчны шинжилгээ, үнэлгээг хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох шаардлага урган гарч байна (Гэрэлтуяа, Т. 2017). Иймд сургалтын орчны нөлөөллийн хүчин зүйлийн судалгаанд пирсоны шинжилгээг хийсэн үр дүнг энэ өгүүлэлдээ оруулж өглөө.

Түлхүүр үг

Хандлага, хүчин зүйл, хамаарал, лекц, лаборатори

Удиртгал

Оюутны суралцах хандлагын онол, арга зүйн харьцуулсан судалгаа. Хандлага хэмээх нэр томъёоны хувьд олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тодорхойлолтоос авч үзвэл, хандлага төлөвшилийг (attitude) “Хувь хүн, эд юмс болон үйл явдалд үзүүлж буй тодорхой үнэлгээ, дүгнэлт бүхий хариу үйлдлийн тогтсон загвар төлөв юм” гэж тодорхойлсон байдаг. Мөн аливаа асуудалд аль өнцгөөс хэрхэн хандах үйлийн баримжааг хандлага (approach) гэж үзэх тохиолдол ч байна.

Монгол хэлний тайлбар толинд хандлагыг “Ямар нэгэн үзэгдэл, бодол, үзэл санааны ерөнхий чиглэл: зөв хандлага (зөвөөр хандах байдал)-ыг хэлнэ” гэжээ. Сургалтын орчны нөлөөллийн шинжилгээ. Сургалтын орчин нь суралцагчдад сэтгэл зүйн болон оюуны чадамжаа нээн эрэл хайгуул хийх, шинжлэн судлах, амьдралд хэрэгцээтэй дадал, чадварыг эзэмших, багш эрдэмтдийн хувьд “юу сурах, хэнээр үйлчлүүлэх”-ээ сонгох эрхийг суралцагчдад олгож, тэдэнд “мэдлэг эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэх, үүргээ гүйцэтгэх нөхцөл болж байх ёстой. Тэгээд ч хүний оюун санааны төлөвшилд сургалтын орчин чухал үүрэгтэй юм. Сургалтын чанарын гол үзүүлэлт нь сургалтын орчин юм бол сургалтын орчинд анги, танхим, сургалтын техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг зэрэг материаллаг орчин чухал

үүрэгтэй ч багш, оюутны харилцаа буюу анги, танхим дахь хичээлийн уур амьсгал чухал үүрэгтэйг мартаж үл болно.

Багш, оюутан нь бие биеэ харилцан хүндэлсэн, багш нь сургах, оюутан нь сурах үүргээ сайтар ухамсарласан байх нь сургалт явуулах таатай орчин болдог. Багш нь оюутнаа дарангуйлсан эсвэл оюутан нь багшаа үл хүндэтгэсэн байхын аль аль нь сургалтын чанарт сөрөг нөлөө үзүүлнэ (Гэрэлт-Од, 2010). Дээд боловсролын байгууллага нь сургалт, судалгаа, олон нийтэд үйлчлэх гэсэн гол гурван чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хувийн их, дээд сургуулиуд олноор үүсгэн байгуулагдаж байгаа өнөө үед эдгээр сургуулиудад бэрхшээлтэй зүйл ихээр тулгарч байна. Ялангуяа хувийн их сургуулиудын материаллаг бааз сул, багшлах боловсон хүчин тааруу, оюутанд үйлчлэх үйлчилгээ явцуу, өөрийн байргүй, түрээсэлдэг асуудлууд байсаар байна.

Оюутны суралцах хандлагад нөлөөлөх орчны нөлөөллийн судалгаа. Гадаадын эрдэмтэн судлаачид оюутны сурах сэтгэлгээний арга барил, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг олноор судалсан байдаг. Иймээс суралцагчдын суралцах хандлагыг хичээлийн орчны шинж чанар (Фабунми, 2007) эсвэл оюутнуудын үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрдөг гэж үзсэн (Риаз,

2011). Сургалтын орчинг хөгжүүлэх, сургалтын талаар Л.В.Занков багш хэт хөнгөн биш өндөр түвшинд явуулж чадваас суралцагчдын оюун ухаан идэвхжиж эрчимтэй хөгжих нөхцөл бүрддэг гэж үзэхэд заах материалыг хэт сунжруулалгүй хурдацтай болговол суралцагчдын оюуны идэвх өрнөж мэдлэгийг өндөр түвшинд эзэмшсэнээр оюуны хөгжлийн түвшин нь дээшилдгийг нотолсон ажээ. Үүнийг П.Я.Гальперин оюуны үйлдлийг шатлан төлөвшүүлэх онолдоо гаргаж ирсэн (Магнус Лиги, Кармен Трасберг, 2017).

Оюутны сургалтын орчин түүний шинжилгээ, онол практикийн асуудлуудыг судалж суралцах орчны үнэлгээг гаргаж ирсэн байна (Гэрэлт-Од, Я. 2010). Их, дээд сургуулийг гадаад орчны хүрээлэлд орших удирдлага, багш, оюутнаас бүрдэх өвөрмөц систем гэж үзжээ (Оюунцэцэг, Л. 2002).

Сүүлийн жилүүдэд АНУ болон дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад дээд боловсрол олгодог байгууллагын “систем түүний орчин” (тухайлбал Э.Турбан, Ж.Мереди́т нар, 1950) гэдэг томъёоллоор загварчлан суралцах орчныг: сургууль, түүний орчин гэж үзээд сургууль нь нийгэмтэй харилцан үйл ажиллагаа явуулдаг байгууллага, нийгмийн институт болдгийн хувьд тус тусдаа бие даасан хэсгүүдээс бүрдэж, хүн амын боловсролын түвшинг тодорхойлж, хүрээлэн байгаа орчноос нийгмийн харилцааны цогц сүлжээ, өвөрмөц соёлоор ялгарна гэж тодорхойлж байна. Тэгээд ч сургууль, сургалтын орчин нь объектын хэвийн үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх ёстой.

Боловсролд сургалтын чанарыг сайжруулахад шууд болон дам байдлаар нөлөөлдөг дараах хүчин зүйлүүд байна. Үүнд:

Сургалтын агуулга, сургалтын орчин, багш ба удирдлагын арга барилын асуудал, сургалт, судалгааны болон, оюутны тооны харьцаа, удирдлагын чадавх, сургалтын хөтөлбөрийн чанар, багтаамж, оюутны үйлчилгээ, үйл ажиллагааны үнэлгээ, хяналтын тогтолцоо түүний найдвартай байдал зэрэг орно.

Тухайлбал, Румын улсын Галатигийн их сургуулийн «Жанере де Жоз» их сургуулийн бүх оюутнуудын суралцах арга барил нь гол хүчин зүйл гэж үзсэн бол бас нэг гол хүчин зүйл нь суралцах хандлага юм гэдгийг тогтоожээ. Энэ судалгааг 200 гаруй бүлэгт явуулсан туршилтын судалгаанд тулгуурласан байна (Валерика Анжелеш, 2009).

Оюутан амжилттай сурч боловсроход хичээлийн анги, танхимын дулаан, гэрэлтүүлэг,

тохь тухтай байдал (эргономик), оюутнуудын дунд тогтсон соёл, уур амьсгал гэх мэт хүчин зүйлүүд нь бидний судалгааны математик загварын нэг болох Пирсоны шинжилгээгээр маш хүчтэй нөлөөтэй гэж гарсан учир оюутны суралцах орчны шинжилгээг хийсэн нь үр дүнтэй үзүүлэлт болж байна гэж үзлээ (Уртнасан, Тамир, 2018).

Энэхүү судалгааны ажлаар сайн мэргэжилтэн бэлдэхэд оюутны суралцах хандлага гол хүчин болж байгааг судалгааны ажлын хүрээнд баталсан. Иймд оюутны суралцах хандлагыг судлах зорилгоор их, дээд сургуулийн оюутан суралцагсдын амжилттай суралцахад нөлөөлж байгаа хүчин зүйлийг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын оюутнуудад хийсэн судалгааны өгөгдлийг зургаар үзүүлэн дараах асуудлуудыг тодруулав (Зураг 1).

1. Оюутан танд сурахад сургалтын орчин нөлөөлнө гэж үзэж байна уу? гэсэн асуултад

Зураг 1

Орчны хүчин зүйлийн үзүүлэлт, эзлэх хувиар гаргасан байдал




Зураг 1-д оюутнуудаас сургалтын орчин суралцах хандлагад нөлөөлж байгааг судалж үзэхэд 79.5%-нь тийм, 20.5%-нь үгүй гэж хариулсан бол Пирсоны хамаарлын коэффициентээр хичээлийн байр, танхим маш хүчтэй, лекц, лабораторийн өрөө хүчтэй, номын сан хүчтэй гэсэн хамаарал гарсан.

Эндээс үзэхэд оюутны суралцах хандлагад эдгээр хүчин зүйлүүд нөлөөлж байна гэдэг нь харагдаж байна (Уртнасан, Мөнхтунгалаг, Сүнжидмаа, 2013).

2. Сургуулийн номын сангийн тав тухтай үйлчилгээ танд бүрэн нийцдэг үү? гэсэн асуултад

Зураг 2

Номын сангийн үйлчилгээний талаарх тоон үзүүлэлт, эзлэх хувиар гаргасан байдал



Зураг 2-д оюутнуудаас номын сангийн орчин суралцах хандлагад нөлөөлж байгааг судалж үзэхэд 79.5%-нь тийм, 20.5%-нь үгүй гэсэн хариултыг өгсөн бол Пирсоны хамаарлын коэффициентоор номын сангийн үйлчилгээ хүчтэй гэсэн хамаарал гарсан. Эндээс үзэхэд оюутны суралцах хандлагад эдгээр хүчин зүйлүүд нөлөөлж байна гэдэг нь харагдаж байна (Уртнасан, Тамир, 2018).

3. Мэргэжлийн хичээлийн ном, сурах бичгийн хүрэлцээ, хангамж хир зэрэг байдаг вэ? гэсэн асуултад

Зураг 3

Мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ, хангамжийн тоон үзүүлэлт, эзлэх хувиар гаргасан байдал




Зураг 3-д оюутнуудаас ном, сурах бичгийн хүрэлцээ, хангамжийн талаар судалж үзэхэд 29.0%-нь маш сайн, 55.0%-нь сайн, 10%-нь хангалттай, 6%-нь хангалтгүй гэсэн үзүүлэлттэй байна. Пирсоны хамаарлын коэффициентоор мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ, хангамж хүчтэй гэсэн хамаарал гарсан. Эндээс үзэхэд оюутны суралцах хандлагад эдгээр хүчин зүйлүүд нөлөөлж байна гэдэг нь харагдаж байна (Уртнасан, Тамир, 2018).

4. Багш нар оюутнууддаа мэргэжлийн зөвлөгөө өгч дэмждэг үү? гэсэн асуултад

Зураг 4

Багш нар оюутнуудаа хэрхэн дэмждэг талаарх тоон үзүүлэлт, эзлэх хувиар гаргасан байдал



Зураг 4-д багш нар оюутнууддаа мэргэжлийн зөвлөгөө өгч дэмждэг эсэх талаар санал асуулга явуулсны үр дүнд судалгаанд оролцсон оюутны 85% нь тийм гэсэн хариулт өгсөн бол 15% нь үгүй гэсэн хариулт өгсөн байна. Пирсоны хамаарлын коэффициентоор багш оюутнуудаа хэрхэн дэмждэг байдал дунд зэрэг гэсэн хамаарал гарсан. Эндээс үзэхэд оюутны суралцах хандлагад эдгээр хүчин зүйлүүд нөлөөлж байна гэдэг нь харагдаж байна (Уртнасан, Мөнхтунгалаг, Сүнжидмаа, 2013). Дараах хүснэгтээр оюутны суралцах орчинд нөлөөлж байгаа гадаад, дотоод хүчин зүйлүүдийг харуулав.

Хүснэгт 1

Оюутны суралцах орчинд нөлөөлж байгаа гадаад, дотоод хүчин зүйлүүд

Хүчин зүйл	Хамаарал	Нөлөөлөл
Гадаад	Сургалтын орчинд байгаль, улс төр-эрх зүй, эдийн засаг, нийгэм-хүн ам зүй, мэдээлэл-технологийн орчин хамаарна.	- Хичээлийн байр, танхим - Лекц, лабораторийн өрөө танхимын хүрэлцээ - Номын сангийн хүрэлцээ хангамж - Багшийн дэмжлэг туслалцаа
Дотоод	Оюутан суралцагчдад сэтгэл зүйн болон оюуны чадамжаа нээн, эрэл хайгуул хийх, шинжлэн судлах, амьдралд хэрэгцээтэй дадал, чадварыг эзэмших, сурах таатай нөхцөлийг бүрдүүлэх, тэдний эрхийг хамгаалах боломж бүрдүүлнэ.	- Сургалтын албаны үүрэг оролцоо - Сургалтын төлбөр

Бидний судалгаанаас үзэхэд гадаад хүчин зүйлийн хамаарал нь давамгайл байдлыг

илэрхийлж байгааг харуулж байна. Мөн түүнчлэн оюутнуудын амжилттай суралцахад оюутнуудын хоорондын харилцааны соёл чухал байр суурь эзэлж байгаа тул дээд боловсрол эзэмшиж байгаа оюутнуудад орчны буюу байгууллагын харилцааны ёс журмыг хэвшүүлэх арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эерэг сэтгэлгээ зөв харилцаанд дадуулах шаардлагатай юм.

Судалгааны үр дүнгийн математикийн боловсруулалт ба загвар. Суралцах хандлагад нөлөөлж байгаа хүчин зүйлийн чанарын шинж тэмдгүүдийн хоорондын хамаарлын хүчийг хэмжих шинжилгээг Пирсоны коэффициент шалган үр дүнг тооцлоо. Пирсоны коэффициент r нь 0-оос 1-ийн хооронд байх бөгөөд 0-д ойрхон бол хамаарал сул байх бөгөөд 1-д ойрхон байх тусам хамаарал хүчтэй байна. Пирсоны коэффициентыг дараах илэрхийллээр тодорхойлно.

$$R_n = \sqrt{\frac{\phi^2}{1 + \phi^2}}$$

Хэрэв:

1. Сул $0 < r < 0,1$;
2. Дунд зэрэг $0,1 < r < 0,2$;
3. Мэдэгдэхүйц $0,2 < r < 0,5$;
4. Хүчтэй - $0,5 < r < 0,7$;
5. Маш хүчтэй $0,7 < r < 1$ хүртэлх байна.

Оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг дараах үзүүлэлтээр хийснээс сургалтын орчны нөлөөллийг харуулав.

- Сургалтын үйл ажиллагааны нөлөө;
- Сургалтын материаллаг бааз ба сургалтын орчин;
- Суралцах хандлагын хүчин зүйлийн нөлөөлөл гэж ерөнхийд нь гурав хуваан авч үзэж хамаарлын хүчийг хэмжих шинжилгээг хийж доор дэлгэрэнгүй тайлбарлан хавсралтаар харуулав.

Сургалтын материаллаг бааз ба сургалтын орчин.

1. Суралцах хандлагад Хичээлийн байр танхим гэсэн асуулт хэр хүчтэй нөлөөлж байгааг Пирсоны коэффициентоос үзвэл: $R=0.9870$ байгаа тул маш хүчтэй хамааралтай байна гэдэг нь харагдаж байна. Үүнийг хавсралтын Пирсоны тооцооны хүснэгтээс харна уу.
2. Суралцах хандлагад Лекц, лабораторийн өрөө гэсэн асуулт хэр хүчтэй нөлөөлж байгааг Пирсоны коэффициентоос үзвэл: $R=0.7221$ байгаа тул хүчтэй хамааралтай байна гэдэг нь харагдаж байна. Үүнийг хавсралтын Пирсоны тооцооны хүснэгтээс харна уу.
3. Суралцах хандлагад Номын сангийн хүрэлцээ хангамж гэсэн асуулт хэр хүчтэй нөлөөлж байгааг Пирсоны коэффициентоос үзвэл: $R=0.7204$ байгаа тул хүчтэй хамааралтай байна гэдэг нь харагдаж байна. Үүнийг хавсралтын Пирсоны тооцооны хүснэгтээс харна уу.
4. Суралцах хандлагад Багшийн дэмжлэг туслалцаа гэсэн асуулт хэр хүчтэй нөлөөлж байгааг Пирсоны коэффициентоос үзвэл: $R=0.3748$ байгаа тул дунд зэрэг хамааралтай байна гэдэг нь харагдаж байна. Үүнийг хавсралтын Пирсоны тооцооны хүснэгтээс харна уу.

Оюутны суралцах хандлагад нөлөөлж буй хүчин зүйлүүд дотроос оюутны суралцах орчин буюу хичээлийн өрөө танхим, номын сан зэрэг нь маш хүчтэй хамааралтай гэж гарч байна. Энэ нь сургалтын орчны судалгааг нэн түрүүнд хийх нь зүйтэй ба түүнд нөлөөлж буй нөлөөллийг гарган тогтоох сургалтын байгууллагын сургалтын чанарт нөлөөлөхүйц судалгаа болно гэж үзэж байна. Дараах хүснэгтээр оюутны суралцах хандлагад нөлөөлөх дотоод хүчин зүйлийн нөлөөллийн шинжилгээний үр дүнгийн тооцооллыг харуулав.

Хүснэгт 2

Сургалтын орчинд хичээлийн байр танхим нөлөөлж байгаа үзүүлэлт

	Орчны нөлөөлөл	муу	дунд	сайн	Корреляц дээр тавигдсан тоо	Пирсоны коэффициент	Пирсон		нөлөөлөл
	Хичээлийн байр танхим								
1	тийм	4	30	60	94		37.7681	0.9870	Маш хүчтэй
		16	900	400					
		2.666	28.125	3600	3630.7917	38.625443262			
	үгүй	2	2	2	6				
		4	4	4					
		0.66667	0.125	0.064516	0.8561828	0.1426971326			
	дүн	6	32	62	100	3631.648			

Хүснэгт 3

Сургалтын орчинд лекц, лабораторийн өрөө нөлөөлж байгаа үзүүлэлт

2	Орчны нөлөөлөл	Муу	Дунд	Сайн	Корреляц дээр тавигдсан тоо		Пирсоны коэффициент	Персон		Нөлөөлөл							
	Лекц, лабораторийн өрөө						1.090018	0.7221	Хүчтэй								
	тийм										1.6721785972	0.4180002602					
													2	30	59	91	
													4	3025	3481		
	0.57143										94.53125	57.06557	152.16825				
	үгүй										3631.648	5	2	2	9		
												25	4	4			
3.57143		0.125	0.065574	3.7620023													
дүн	7	32	61	100	155.9303												

Хүснэгт 4

Сургалтын орчинд номын сангийн хүрэлцээ хангамж нөлөөлж байгаа үзүүлэлт

3	Орчны нөлөөлөл	Муу	Дунд	Сайн	Корреляц дээр тавигдсан тоо	Пирсоны коэффициент	Пирсон		Нөлөөлөл
	Номын сангийн хүрэлцээ, хангамж								
	тийм	4	40	47	91		1.07912	0.7204	Хүчтэй
		16	1600	2209					
		1.77778	38.09524	45.08163	84.954649	0.9335675662			
	үгүй	5	2	2	9				
		25	4	4					
		2.77778	0.095238	0.081633	1.31	0.1455555556			
	дүн	9	42	49	100				

Хүснэгт 4

Сургалтын орчинд багшийн дэмжлэг нөлөөлж байгаа үзүүлэлт

4	Орчны нөлөөлөл	муу	дунд	сайн	Корреляц дээр тавигдсан тоо	Пирсоны коэффициент	Пирсон		нөлөөлөл
	Багшийн дэмжлэг								
	тийм	4	55	35	94		0.16349	0.3748	Дунд зэрэг
		16	3025	1225					
		2.66667	53.07018	33.10811	88.84495				
	үгүй	2	2	2	6				
		121	4	4					
		20.1667	0.070175	0.108108	1.31				
	дүн	6	57	37	100				

Судалгаагаар хичээлийн байр танхим, лекц, лабораторийн өрөө, номын сангийн хүрэлцээ, хангамж, багшийн дэмжлэг гэсэн 4 үзүүлэлтээр зохих түвшний хамаарлуудыг гаргасан нь оюутны суралцах хандлагыг тодорхойлсон тоон үзүүлэлт болж өглөө.

Дүгнэлт

Судалгааны ажлын дүгнэлтээр сүүлийн таван жилд ШУТИС-ийн дөрвөн бүрэлдэхүүн

сургуулийн сүүлийн 5 жилийн дундаж тоон үзүүлэлтийн нийт 36609 элсэгчдээс мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцаагүй оюутны эзлэх хувь 28,68% байгаа нь ЕБС-ийг төгсөөд мэргэжил сонголтыг өөрийн сонирхсон чиглэлээр хийж чадаагүйг харуулж байна.

Анкетын судалгаа болон Пирсоны шинжилгээний коэффициент нь 0,933 буюу оюутныг амжилттай суралцахад маш хүчтэй нөлөөтэй гарсан нь сургалтын орчныг тооцож үзэх шаардлагатайг гэдэг нь харагдлаа.

ШУТИС-ийн нийт 593 оюутнуудаас анкет, асуумж судалгаа, хэмжилт туршилтаар гаргасан суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд 2007-2017 оны оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааны дүнгээр 10 хувьсагчтай регрессийн тэгшитгэл бүхий математик загвар боловсруулж хүчин зүйлийн хүчтэй ба сул хамаарлуудыг тодорхойлов. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагааны нөлөөллөөр дээд боловсрол эзэмших маш хүчтэй, ажлын байртай болох мэдэгдэхүйц, санхүүгийн хэрэгцээ мэдэгдэхүйц, мэргэжлээрээ өсөх бололцоотой нь сул хамааралтай;
- Сургалтын материаллаг бааз ба сургалтын орчны нөлөөллөөр хичээлийн байр танхим маш хүчтэй, лабораторийн өрөөний орчны нөлөө, номын сангийн хүрэлцээ хангамж хүчтэй, эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах нь мэдэгдэхүйц хамааралтай;
- Суралцах хандлагын хүчин зүйлийн нөлөөллөөр оюутнуудын хоорондын харилцаа ёс зүйн асуудал нь маш хүчтэй, сурах танин мэдэхүй хүчтэй, бүтээлч байх асуудал нь хүчтэй, сурах үйлтэй холбоотой мэдэгдэхүйц, өөрөөс хамаарсан нь мэдэгдэхүйц хамааралтай байна. Үүнээс үзэхэд эдгээр хүчин зүйлүүд нь оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн нэг тул суралцах хандлагыг тодорхойлон тогтооход шаардлагатай үзүүлэлтүүд гарч байна.

Ном зүй

- Авдай, Ч., Энхтуяа, Д. (2000). Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй, Статистик боловсруулалт, загварчлал, оновчлол. Улаанбаатар. 352х.
- Бэгз, Н. (2008). Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд.
- Бэгз, Н. (2011). Монголын боловсрол судлалын шинэ парадигм.
- Бадарч, Д. (2017). Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь. Улаанбаатар. 16х, 38-39х
- Бадарч, Д. (2013). Дээд боловсролын шинэчлэлийн инноваци. Өгүүлэл. Улаанбаатар.
- Балтзерсен, Ж. (2007) Хүүхэд хэрхэн суралцдаг тухай. Мэдээлэл. Улаанбаатар. 104-111х.
- Батхуяг, С. (2012). Амжилттай суралцах арга зам, Содпресс ХХК.
- Батхуяг, С. (2003). Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй.

Валерика, Анжелеш. (2013). Суралцагчдын хандлагад нөлөөлөх хүчин зүйлийг судлах нь диссертаци, Румын улс

Гэрэлт-Од, Я. (2010). Оюутны суралцах орчны үнэлгээ, Магистрын ажлын бүтээл. Улаанбаатар.

Гэрэлтуяа, Т. (2017). Оюутны суралцах хандлагад хийсэн дүн шинжилгээ (МУБИС-ийн СӨБСС-ийн 1, 2-р курсийн оюутнуудын жишээн дээр) МУИС, Боловсрол судлал сэтгүүл. Улаанбаатар. №17(469). 169-171х.

Лхагвасүрэн, Ч. (2012). Дээд сургуулийн оюутны суралцах чадварын төлөвшлийг судалсан нь, диссертаци. Улаанбаатар.

Оюунцэцэг, Л. (2001). Сургалтын орчны хүчин зүйлийн судалгаа. Улаанбаатар.

Уртнасан, Г., Мөнхтунгалаг, Е., Сүнжидмаа, Т. (2013). Оюутны сурах үйлийн хүрээнд сурах орчин, нөхцөл байдалд дүн шинжилгээ өгөх нь, Их, дээд сургуулиудын онол практикийн бага хурал. Улаанбаатар.

Уртнасан, Г., Тамир, Х. (2018). Их, дээд сургуулийн оюутны суралцах хандлагыг үнэлэх сургалтын орчны нөлөөллийн судалгаа, ШУТИС, ЕНИ, Олон улсын онлайн хурал. Улаанбаатар.

Миронов Б.Н., Степанов З.В., *Историк и Математика (математические методы в историческом исследовании)*, Москва. (2014).

Русских, Л.В., Отношение студентов к учебе как показатель ценности образованич. (2017)

Усова, А.В., Бобров А.А. Формирование у учащихся учебных умений. Педагогика и психология. (1987, №7).

ADEA. (2003). *Case study on distance education for teacher education in Mauritius. ADEA Biennial Meeting*, Mauritius.

MUST, *E-Open institute, International online conference, Ulaanbaatar, Mongolia*. (2018, 57-62, 68-73, 74-77).

James Brian Quinn., *Intelligent Enterprise*, (1992).

Somboon Chetchumlong., (2010). *The effect of web-based formative assessment on students' achievement and attitudes in a large enrolment tertiary English course*.

Valerica Anghelache., *Determinant Factors of Students' Attitudes Toward learning*, <https://doi.org/10.1016/j.sbspro.2013.09.223>, pages 478-482

Магнус Лиги, Кармен Трасберг, Причины недобросовестности в учебе и представления студентов о правилах поведения, Тартуского университета, (2017).

www.agepedagog.ru/ Понятие <отношение> к

обучению в педагогической науке. (2018).
<https://psyera.ru/3436/psihologicheskie-fakto-ry-opredelyayushchie-ushpeshnost-ucheb-noy-deyatelnosti> Ишков А.Д., Учебная деятельность студента, (2012).
http://bataabaatar.blogspot.com/2015/03/blog-post_19.html /Learning theories/.

Жизненные стратегии как фактор отношения студентов в учебной деятельности тема диссертации и автореферата по ВАК 19.00.07, кандидат психологических наук Воронина, Ольга Александровна. (2008).

A study on the factors influencing learning attitudes of students

Urtnasan.G, Erdenetuya.S
Mongolian University of Science and Technology

Abstract

However training towards to improvements of students' knowledge, ability and approach in real to assess mostly on the students knowledge and ability improvement but not on the students approach improvement. Our aim is to determine factors influence that need to assess and evaluate studying approach of the students or choosing professions by the students. Therefore we consider that we should create studying approach model, reveal influence factors for the students' studying approach and also indentify principles. In addition to these we should try to choose a possible way of studying approach, and try to sum up analyses of the factors and results (method of GRV and GDV scientific laboratory) of the study, as well as to carry out experiments

Keywords

Attitude, factor, relationship, lecture, laboratories
